

БНХАУ-ЫН ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ ТУРШЛАГА БА ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨ

EXPERIENCE AND EFFICIENCY FOR COMBATING ON ILLICIT CIRCULATION OF
NARCOTIC AND DRUG BY CRIMINAL LAW OF PEOPLE'S REPUBLIC OF CHINA



ХҮҮЛЬ
САХИУЛАХУЙ



Д.УНДРАЛСАЙХАН

ХЗЯ-ны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн,
хууль зүйн доктор

UNDRALSAIKHAN.D

Officer of Treaty, law and cooperation department of Ministry of Justice, Ph.D

Товч агуулга: Энэхүү судалгаагаар БНХАУ-ын эрүүгийн хуульд тусгагдсан хар тамхи, мансууруулах бодисын эрх зүйн онцлог зохицуулалтыг судлах замаар өөрийн орны хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг багасгах, хуулийн үр нөлөөг дээшлүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал дэвшүүлэхийг зорив.

Abstract: This paper studies China's criminal law on drugs and drug specific legal regulations and through this research to reduce drug use, improve the effectiveness of law and legal framework on drugs of our country.

Түлхүүр үгс: БНХАУ-ын Эрүүгийн хууль, Монгол Улсын Эрүүгийн хууль,

Abstract: This paper studies China's criminal law on drugs and drug specific legal regulations and through this research to reduce drug use, improve the effectiveness of law and legal framework on drugs of our country.

Түлхүүр үгс: БНХАУ-ын Эрүүгийн хууль, Монгол Улсын Эрүүгийн хууль, хар тамхи, ялын төрөл.

Key words: Criminal law of PRC, Criminal law of Mongolia, narcotic, type of penalty.

Монгол Улс дэлхий ертөнцийн глобальчлалыг даган, техник технологи, интернетийн хөгжил дэвшил нэвтэрч, хэвлэл мэдээллийн урсгал чөлөөтэй болж, иргэд хил гаалиар чөлөөтэй зорчих болсонтой холбоотой шинэ төрлийн гэмт хэрэг, түүний дунд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодис манай оронд хууль бусаар орж ирэх, дамжин өнгөрөх, түүнийг тээвэрлэх үзэгдэл нэмэгдэж, тэдгээрийг хэрэглэгчид, тээвэрлэгчид,

дамжин өнгөрүүлэгчдийн хууль бус сүлжээ бий болж, улмаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл бодисын хууль бус наймаанд залуучууд тэр дундаа өсвөр үеийнхэн ихээр өртөн, түүнд татагдан орж, хар тамхины хэрэглээ жил ирэх бүр өсөн нэмэгдэх хандлагатай болж байна. Энэ талаар Үндэсний хэмжээнд хийгдсэн тодорхой судалгаа одоогоор гараагүй. Харин "Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг"-ээс



улсын хэмжээнд мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо болон голчлон ямар бодис хэрэглэж байгаа талаар судалгаа явуулсан байна. 1999 оны судалгаагаар 45 хүн хар тамхи хэрэглэдэг байсан бол 2014 оны байдлаар 600 хэрэглэгчтэй болсон судалгаа байна¹. Энэ бол зөвхөн судалгаагаар илэрсэн хэрэглэгчид. Үүний цаана хичнээн хэмжээний бүртгэгдээгүй хэрэглэгч байгааг хэлэхэд хэцүү бөгөөд жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Хэдийгээр Монгол Улс Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөлөх бодисуудын тухай 1971 оны конвенцид 1999 онд нэгдсэн бол Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисуудын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын 1988 оны конвенцид 2001 онд тус тус нэгдсэн ч энэ төрлийн үндэсний бие даасан цогц хуульгүй, мөн эрүүгийн хуульд тусгагдсан зохицуулалтууд өнөөгийн нөхцөл байдалд хангалтгүй зэрэг нь маш том асуудал болж байгаа юм. Түүнчлэн хар тамхи мансууруулах бодисын том зах зээл болох БНХАУ-тай хөрш зэргэлдээ орших бид энэ талаар дорвитой арга хэмжээ авч, хууль эрх зүйн зохицуулалт, холбогдох дүрэм журмаа боловсронгуй болгох, нөгөөтэйгүүр туршлага солилцох, суралцах, хууль дүрмийг судлах шаардлага нэн түрүүнд бий болоод байна. Хятад улс манай улстай харьцуулахад хар тамхи мансууруулах бодисын талаар эрх зүйн зохицуулалтын хувьд харьцангуй туршлагатай, чанга хатуу төрөлжсөн хуультай мөн хөрш улсын хувьд энэхүү сэдвийг сонгон өөрийн санал дүгнэлтээ дэвшүүлэхийг зорилоо.

БНХАУ 1979 онд Ардын Их Хурлаар шинэ Эрүүгийн хуулийг баталж түүнээс хойш 1997, 1999, 2002, 2005 болон 2006, 2011, 2015 онуудад тус тус нэг удаа, 2001, 2009 онуудад тус тус 2 удаа нэмэлт өөрчлөлтийг хийж иржээ².

¹ Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх нийгэмлэгийн албан ёсны цахим хуудас, <http://monantidrug.blogspot.com/>

² БНХАУ-ын Эрүүгийн хууль. 1979.

БНХАУ-ын Эрүүгийн хуульд хар тамхитай холбоотой үүсэх гэмт хэрэг нь хар тамхийг хил давуулах, худалдах, тээвэрлэх, үйлдвэрлэх, хадгалах зэрэг хууль бус үйлдлээр бий болдог.

1. Хар тамхи хил давуулах болон тээвэрлэх

Хар тамхийг хил давуулах нь тухайн этгээд хил давуулах гэж буй зүйлээ хар тамхи гэдгийг мэдэж байгаа ба түүнийг тээвэрлэх, хэн нэгэнд дайх, шуудан илгээмжээр улсын хилээр гаргах болон оруулахыг ойлгоно. Мөн нэгэнт хилээр орж ирсэн хар тамхийг шууд хүлээн авч өөрсдийн дотоод далайд тээвэрлэн мөн хүлээн авсан, худалдсаныг хар тамхи хил давуулах хууль бус үйлдэлд хамааруулдаг байна. Тухайлбал, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 347 дугаар зүйлд: "Хар тамхины хэмжээ ямар байхаас үл хамааран хил давуулах, худалдаалах, тээвэрлэх зэрэг аливаа хууль бус үйлдэлд зайлшгүй эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж заасан байна. Ер нь Хятадад хар тамхи, мансууруулах бодисыг газар, далай, агаар гэсэн төрлөөр нууцаар тээвэрлэн хил давуулдаг.

2. Хар тамхи худалдаалах

Хар тамхи худалдаалах нь тухайн этгээд худалдаж буй зүйлээ хар тамхи гэдгийг мэдэж байгаа бөгөөд түүнээс ашиг хонжоо олох зорилгоор бусдад зарж борлуулахыг ойлгоно. Өөрөөр хэлвэл хар тамхийг худалдан авагчид шилжүүлэн өгч оронд нь төлбөр авснаар уг үйлдэл нь төгсөж төгссөн гэмт хэрэг болно. Тухайлбал: БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 347 дугаар зүйлд: "Хэрэв 50 кг дээш 1000 кг доош Опиум, 2.5 кг дээш 12.5 кг доош хэмжээтэй Героин болон Метафенамин ба өөр бусад хар тамхийг хил давуулах, худалдаалсан бол..." гэсэн заалт бий.

3. Хар тамхи үйлдвэрлэх

Хар тамхины эх үүсвэр болох ургамлыг ашиглан шууд боловсруулах замаар эсвэл химийн аргыг ашиглан хар тамхи гарган авахыг ойлгоно.

4. Хар тамхи хадгалах

Хар тамхи гэдгийг мэдэж байгаа бөгөөд түүнийг эзэмших, нууцлах



болон өөр бусад аргаар түүнийг өөрийн мэдэлдээ байлгаж байгаа аливаа үйлдэл нь хар тамхи хадгалсан гэмт хэрэгт тооцогддог байна. Тухайлбал: Эрүүгийн хуулийн 348 дугаар зүйлд: “50 кг дээш 250 кг доош хэмжээний Опиум, 2.5 кг дээш 12.5 кг доош хэмжээтэй Героин болон Метафенамин түүнчлэн их хэмжээтэй өөр бусад хар тамхи хадгалсан бол...” гэж заасан байна.

Ерөнхийдөө Хятад улсад хар тамхитай холбоотой эрх зүйн зохицуулалтыг БНХАУ-ын “Эрүүгийн хууль”, “Хар тамхийг хориглох тухай” бие даасан хууль болон эрх бүхий байгууллагын гаргасан дүрэм, журмаар зохицуулдаг. Хар тамхины гэмт хэрэг нь “Хар тамхийг хориглох тухай хууль”-ийг зөрчин, хар тамхины бусад хууль, эрх зүйн зохицуулалтад харшилсан нийгэмд аюултай шинж чанартай, эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэх тийм үйлдэл юм ³.

БНХАУ 1997 онд Эрүүгийн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулахдаа анх удаа хар тамхитай холбоотой зохицуулалтыг оруулсан бөгөөд үүнд хар тамхины төрөл, хэмжээ болон хар тамхины гэмт хэрэгт тооцох үндсэн жишгийг тогтоон хүлээх хариуцлагыг нарийн тодорхойлж өгсөн байна.

БНХАУ-ын Эрүүгийн хуульд заасан хар тамхитай тэмцэх зохицуулалт нь Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан зохицуулалттай адил тал байгаа ч мөн онцлог ялгаатай. Үүнд:

1. Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлүүдийн нэр томъёог салган

тодорхойлж мөн тэдгээрийн хэмжээг тус тусад нь зааглан тодорхойлж өгсөн нь тухайн мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эмийн хор хөнөөл, нөлөөллийн агууламжид үндэслэн ялыг оновчтой онооход ач холбогдолтой юм. Тухайлбал: БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 348 дугаар зүйлд: “250 кг дээс опиум, 12.5 кг дээш героин, метафенамин болон бусад төрлийн мансууруулах бодисоос их хэмжээгээр хууль бусаар эзэмшиж байсан бол...”

³ “Хар тамхины гэмт хэргийн мөн чанарыг судлах нь” (Хятад хэл дээрх нийтлэл). 2014.

мөн тус хуулийн 355 дугаар зүйлд: “ Улсын хамгаалалтад байх мэдээ алдуулагч эм болон сэтгэцэд нөлөөлөх мэдрэлийн эмийг хууль бусаар үйлдвэрлэх, тээвэрлэх, хэрэглэвэл...” гэж тус тус салган ангилсан Түүнчлэн мансууруулах бодисын хэмжээг зүйл тус бүрт өөр өөр байдлаар тодорхойлж өгсөн. Тухайлбал: БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 347 дугаар зүйлд: “ 250кг дээш хэмжээтэй Опиум, 12.5 кг дээш хэмжээтэй Героин эсвэл Метафенамин болон бусад төрлийн хар тамхи их хэмжээгээр хил давуулах, худалдах, тээвэрлэвэл...” гэж заасан байна.

2. Байгууллагад хуулийн хариуцлага ноогдуулдаг байна. Тухайлбал: БНХАУ-ын

Эрүүгийн хуулийн 347 дугаар зүйлд: Тус зүйлд заасныг аль нэг байгууллага зөрчвөл мөнгөн торгууль ноогдуулахаас гадна, тухайн байгууллагыг хариуцаж буй этгээд болон шууд харьяалагдах этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага тооцно”.

3. Насанд хүрээгүй этгээдийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалсан зохицуулалт хийж өгсөн. Энэ нь мөн тус улсын Эрүүгийн хуулийн 347 дугаар зүйлд: “Насанд хүрээгүй этгээдийг хар тамхи хил давуулах, худалдаалах мөн тээвэрлэхэд ашигласан, өдөөн хатгасан этгээдэд хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар ял онооно”.

4. Мансуурах бодис хэрэглэгчдийн хүрээг хязгаарлах, шинээр мансууруулах бодис, хар тамхи хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, тийм үйлдэл гаргагчдад хариуцлага хүлээлгэх зохицуулалт хийж өгсөн байна. Тухайлбал: БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 353 дугаар зүйлд: “ Хэн нэгнийг өдөөн хатгах, турхирах болон хууран мэхлэх замаар түүнчлэн хүч хэрэглэн хар тамхи, мансууруулах бодис хэрэглүүлсэн бол тухайн этгээдийг хамгийн багадаа 3 жилийн хугацаагаар хорих эсвэл торгоно, хэрэв энэ нь ноцтой гэж үзсэн тохиолдолд 3 доошгүй 7 жилээс дээшгүй хугацаагаар хорино. Хэрэв бусдад хүч хэрэглэн хар тамхи,



мансууруулах бодис хэрэглүүлсэн нь ноцтой гэж үзвэл 3 жилээс доошгүй 10 жилээс дээшгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ”.

5. Хар тамхи, мансууруулах бодис агуулсан бүтээгдэхүүнд хяналт тавьдаг. Тухайлбал: тус улсын Эрүүгийн хуулийн 350 дугаар зүйлд: “ Хар тамхи, мансууруулах бодис бүхий бүтээгдэхүүнийг хууль бусаар хил давуулах, худалдах болон тээвэрлэх, улсын хууль тогтоомжийг зөрчин ацетат буюу цууны хүчлийн давс, эфир болон хлороформ зэрэг өөр бусад хар тамхи, мансууруулах бодисыг бүтээхэд оролцдог эх үүсвэрийг эсвэл тухайн бодис орсон бүтээгдэхүүнийг улсын дотор хууль бусаар худалдсан бол...”.

6. Мансууруулах бодис агуулсан ургамлыг худалдах зохицуулалтад тухайн ургамлын төрөл, хэмжээг мөн тусгасан байдаг. Тухайлбал: БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 351 дүгээр зүйлд: “Намуу цэцэг, Канабис зэрэг ургамлыг тарьж ургуулсан бол түүнийг устгаж, дараах тохиолдолд тухайн этгээдэд 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэн мөн мөнгөн торгууль ноогдуулна:

1. Намуу цэцгийг 500 дээш 3000 доошгүй бут болон бусад төрлийн ургамлаас их хэмжээгээр ургуулсан бол;

2. Цагдаагийн байгууллагаар шалгагдсаны дараа мөн дахин ургуулсан бол;

3. Устгуулахаас зайлсхийсэн бол;

Хэрэв Намуу цэцгийг 3000 бутаас дээш хэмжээгээр болон бусад ургамлыг их хэмжээгээр ургуулсан бол 5 дээш жилээр хорих ял шийтгэн мөн мөнгөн торгууль ноогдуулна.

Хэрэв Намуу цэцэг болон бусад ургамлыг ургуулан түүнээс ашиг олохоос өмнө сайн дураар устгавал мөнгөн торгуулиас чөлөөлөгдөнө” гэж заасан.

7. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой аливаа хууль бус ажиллагаанд оногдуулах ялын хэмжээ өндөр байхаар заасан. Тухайлбал: БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 347 дугаар зүйлд: “ Хар тамхины хэмжээ ямар байхаас үл хамааран хил давуулах,

худалдах, тээвэрлэх зэрэг аливаа хууль бус үйлдэлд зайлшгүй эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хар тамхийг хил давуулсан, худалдаалсан, тээвэрлэсэн этгээдэд дараах тохиолдолд 15 жилээс дээш хугацаагаар эсвэл хугацаагүй хорих ялаар шийтгэх мөн цаазаар явах ял оноож түүнчлэн эд хөрөнгийг хураана. Үүнд:

1. 250 кг дээш опиум, 12.5 кг дээш героин, метафенамин болон бусад төрлийн хар тамхи, мансууруулах бодисыг их хэмжээгээр хил давуулсан, худалдаалсан болон тээвэрлэсэн бол;

2. Хар тамхийг хил давуулах, худалдах болон тээвэрлэх, хар тамхи үйлдвэрлэх зорилгоор бүлэг байгуулсан бол;

3. Өнгөлөн далдлалт хийн хар тамхийг хил давуулах, худалдах болон тээвэрлэсэн бол;

4. Хар тамхи тээвэрлэх зорилгоор олон улсын хууль бус сүлжээнд нэгдсэн бол;

Хэрэв 50 кг дээш 1000 кг доош Опиум, 2.5 кг дээш 12.5 кг доош хэмжээтэй Героин болон Метафенамин ба өөр бусад хар тамхийг хил давуулах, худалдах болон тээвэрлэвэл 7 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэн мөн мөнгөн торгууль ноогдуулна.

Түүнчлэн: БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 348 дугаар зүйлд: “250 кг дээш Опиум, Героин, Метафенамин 12.5 кг дээш болон өөр бусад хар тамхийг их хэмжээгээр хадгалсан бол 7 жилээс дээш болон хугацаагүй хорих ялаар шийтгэн түүнчлэн мөнгөн торгууль ноогдуулна. 50 кг дээш 250 кг доош хэмжээний Опиум, 2.5 кг дээш 12.5 кг доош хэмжээтэй Героин болон метафенамин түүнчлэн их хэмжээтэй өөр бусад хар тамхи хадгалсан бол 3 жилээс дээш 7 жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

Мөн тус хуулийн 350 дугаар зүйлд: “ Хар тамхи, мансууруулах бодис бүхий бүтээгдэхүүнийг хууль бусаар хил давуулах, худалдах болон тээвэрлэх, улсын хууль тогтоомжийг зөрчин ацетат буюу цууны хүчлийн давс, эфир болон хлороформ зэрэг өөр бусад хар



тамхи, мансууруулах бодисыг бүтээхэд оролцдог эх үүсвэрийг эсвэл тухайн бодис орсон бүтээгдэхүүнийг улсын дотор хууль бусаар худалдсан бол 3 жилийн хугацаагаар хорих ял шийтгэж, хэрэв тухайн бүтээгдэхүүн их хэмжээтэй бол 3 дээш 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэн түүнчлэн мөнгөн торгууль ноогдуулна” гэж заасан байна.

Дээрх хуулийн заалтуудаас харахад үйлдсэн гэмт үйлдлийн төрөл, хар тамхины хэмжээ, төрлөөс үндэслэн гэмт хэрэгтэнд оноох ялын хэмжээ хамгийн багадаа 3 жил, 5 жил, 7 жил, 10 жил, 15 жил болон түүнээс дээш мөн хугацаагүй хорих ял түүнчлэн цаазаар авахаар заасан байна. Мөн хугацаатай хорих ялын хажуугаар мөнгөн торгууль оногдуулах, зарим тохиолдолд тухайн гэмт хэргийг хүнд хэлбэрийн гэмт хэрэг гэж үзвэл хугацаагүй хорих эсвэл цаазаар авах ялын хажуугаар бүх хөрөнгийг хураадаг заалттай байна. Энэ нь тухайн гэмт хэрэгтэнд хийсэн үйлдэлд нь хорих болон цаазаар авахаас гадна их хэмжээний мөнгөн торгууль ноогдуулах, эд хөрөнгийн хураах нь цаашлаад ар гэр, өмч хөрөнгө, эдийн засагт нь хүчтэй нөлөөлөх тийм хатуу шийтгэлийг оноож байгаа хэрэг юм. Өөрөөр хэлвэл хар тамхитай холбогдсон л бол тухайн хүн нийгэмд эзлэх байр суурь, амьдралын баталгаагүй болох тийм хатуу шийтгэл хүлээж байна гэсэн үг юм.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2002 онд шинэчлэгдэн батлагдсан Эрүүгийн хууль нь 13 жилийн турш нийгмийг гэмт хэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоохтой холбогдсон харилцааг зохицуулахдаа цаг үеийн нөхцөл байдал, эрэлт хэрэгцээ зэргээс улбаалан 10 удаа нэмэлт өөрчлөлт оруулснаас 2008 онд хар тамхи, мансууруулах бодисын заалтад нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна. Гэвч нийгмийн хөгжлийг дагаад, өчигдөр шинэчилсэн хуулийн заалт өнөөдөр хуучирч “үүргээ” бүрэн биелүүлэх боломжгүйд хүрч хуулиа дахин эргэж харахыг шаардах бөгөөд манай улсад

хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг буурахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг зохицуулах, эрх зүйн зохицуулалт боловсроогүй, өнөөгийн нөхцөл байдалд бүрэн нийцэхгүй байгаатай холбоотой юм.

Манай улсад үйлчилж буй Эрүүгийн хууль дахь хар тамхи, мансууруулах бодистой холбоотой заалт нь доорх учир дутагдалтай байгаа юм. Үүнд:

1. Хар тамхи, болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын нэр төрөл түүний

хор хөнөөлийн агууламж, нөлөөллийн зэрэглэл, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэмжээг тодорхойлж нарийн заагаагүй. Хуульд зөвхөн онц их хэмжээ гэдэг байдлаар тусгасан нь ял онооход учир дутагдалтай байдаг ⁴. Тийм учир манай улс эрүүгийн хуульдаа хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, эм бэлдмэлийг төрөл, хэмжээг нарийвчлан зааглан тогтоож, ялын хэмжээг аль болох хар тамхины гэмт хэрэг тухай бүрт тохируулан оноож болохуйцаар тусгаж өгөх шаардлагатай байна. Учир нь хар тамхины гэмт хэргийн гаралт, үйлдэгдэж буй байдал, өдрөөс өдөрт улам төвөгтэй болох энэ асуудлыг өнөөгийн эрүүгийн хуулийн хэдхэн заалт хангалттай зохицуулж чадахгүйд хүрэх магадлалтай байгаа юм.

2. Зөвхөн хадгалсан, дамжуулсан, худалдсан, тээвэрлэсэн гэсэн зүйл заалтаар шийтгэл оногдуулах

⁴ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах. 192.1.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 192.2.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.192.3.Энэ хуулийн 192.2-т заасан хэргийг:192.3.1. онц их хэмжээгээр;



зохицуулалттай бөгөөд хар тамхи хэрэглэсэн үйлдэлд ял, шийтгэл хүлээлгэх талаар заалт байхгүй⁵. Зөвхөн хадгалсан, дамжуулсан, худалдсан, тээвэрлэсэн гэсэн зүйл заалтаар шийтгэж байгаа нь мансуурах бодис хэрэглэгчдийг өөгшүүлэх хуулийн нэг цоорхой болж байгаа юм. Манай улсын Эрүүгийн хуулинд хэрэглэсэн гэсэн зүйл анги байхгүй бөгөөд зөвхөн хэрэглэх газар зохион байгуулсан гэдэг зүйл ангийн зохицуулалт байна. Хэн нэг этгээд хар тамхи хэрэглэсэн нь тогтоогдвол оноох ялын хэмжээ, төрөл заалт байдаггүй. Хэрэглэсэн гэсэн заалтыг Эрүүгийн хуульд мөн ялгавартайгаар тусгах нь зүйтэй. Тухайлбал: Хар тамхийг өөрийн сонирхлоор хэрэглэсэн; Бусдыг хар тамхи хэрэглэхэд уруу татах; Хар тамхийг бусдад хүчээр хэрэглүүлэх; Хар тамхийг бүлэглэн хэрэглэх гэх мэтээр ангилан мөн тус тусад нь задалж болох юм.

3. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой аливаа хууль бус ажиллагаанд оногдуулах ялын хэмжээ сул. Жишээ нь, хар тамхи худалдах зорилгоор тээвэрлэсэн, борлуулсан болон илгээсэн тохиолдолд манай улсын эрүүгийн хуулийн заалтад 5-8 жилийн хугацаагаар хорих шийтгэнэ гэж заасан, гэвч энэ заалтад тухайн тээвэрлэсэн, борлуулсан болон илгээсэн хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын төрөл, хэмжээг нарийн заалгүй тухайн төрлөөр хууль зөрчсөн этгээдэд оногдуулах ялын хэмжээг шууд зааж байгаа бөгөөд ялын хэмжээ бага байгаа юм. Тухайлбал: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт, 192 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан,

тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Харин дээр заасан хэргийг онц их хэмжээгээр, насанд хүрээгүй хүн оролцуулж, онц аюултай гэмт хэрэгтэн, үгсэн тохиролцон буюу зохион байгуулалттайгаар үйлдсэн бол 10-15 жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байна. Харин БНХАУ-ын Эрүүгийн хуульд хар тамхины төрөл, хэмжээнээс хамаараад хамгийн багадаа 3 жил, ерөнхийдөө 7 жилээс дээш, 15 жилээс дээш хугацаагаар эсвэл хугацаагүй хорих ялыг мөнгөн торгууль, эд хөрөнгө хураахтай хамт оногдуулдаг. Мөн мансууруулах бодис агуулсан ургамлыг тарьж ургуулсан этгээдэд ноогдох ялын дээд хэмжээ манай улсад 5 жил хүртэл байдаг бол Хятад улсад мөн ургамлын төрөл, хэмжээнээс хамаараад 3 болон 5 дээш хугацаагаар хорьж мөн мөнгөн торгууль ноогдуулдаг байна. Тухайлбал: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 195 дугаар зүйлийн 1 дэхь хэсэгт: “Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарьсан, ургуулсан, хурааж авсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан бол Хятад улсын Эрүүгийн хуулийн 351 дүгээр зүйлд (тус заалтыг дээр дэлгэрэнгүй тусгасан байгаа) энэ талаар заасан байна.

Монгол Улсад Эрүүгийн хуулийн (шинэчилсэн найруулга) батлагдан улмаар 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх юм. Тус шинэчилсэн найруулгад хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтэй тэмцэх, тэдгээрт оногдуулах ялын санкцид буюу зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүсэх хууль зүйн үр дагаварт шинэ төрлийг оруулж өөрчлөлт хийсэн. Тухайлбал: Шинэчлэгдсэн Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах⁶...” · 20.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Мансууруулах

⁵ Мөн 192 дугаар зүйлийг харна уу.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.



эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх орон байраар хангасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах...", 20.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасах таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах...", 20.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах..." гэж тус тус шинэ ялын төрлийг нэмж оруулсан нь өмнөх хуулийн "шоронжсон" байдлаас татгалзаж, яллагдагчийн засрал хүмүүжлээс шалтгаалан ялын хэмжээг уян хатан байлгахаар зохицуулсан байна.

Түүнчлэн хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусад нь бүлэг болгож, хуулийн этгээдийн өмнөөс хувь хүн хариуцлага хүлээдэг байсныг өөрчилсөн. Хуульд заасан хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд торгох, эрх хасах, татан буулгах ял оногдуулахаар заасан байна. Тухайлбал: 20.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ".

Сүүлийн үед манайд төрийн эрх бүхий албан хаагчид хар тамхины гэмт хэрэгт холбогдох нь ихсэж албан

тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглан энэ төрлийн гэмт хэрэгт татагдах болсон ч одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд хууль бус үйлдэлд хариуцлага хүлээлгэх хуулийн заалт байгаагүй, харин Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нөхөж оруулсан байна. Тухайлбал: 20.9 дүгээр зүйлд: "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасах таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ".

"Шинэ" Эрүүгийн хуульд хар тамхины хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдэд ялаас чөлөөлөх байдлыг уян хатан зохицуулахаар заасан. Хэдийгээр хар тамхи гэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын гэмт хэрэг өөрөө маш их хор хөнөөлтэй, сөрөг үр дагавар ихтэй, хатуу чанга хариуцлага хүлээлгэх гэмт хэрэг хэдий ч сүүлийн үед өсвөр залуу үе энэ төрлийн гэмт хэрэгт уруу татагдан "хохилогч" болох хандлага ихсэж, хийсэн хэрэгтээ гэмших, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн тохиллолд ялаас чөлөөлөхөөр заасан байна. Гэх мэтчилэн ирэх 9 дүгээр сараас мөрдөгдөж эхлэх Эрүүгийн хуульд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хуулийн заалтад маш олон өөрчлөлт орсон хэдий ч хар тамхи, мансууруулах бодисыг хэрэглэсэн, түүнд

донтсон хүнд хүлээлгэх хариуцлагын талаар тусгагдаагүй бөгөөд энэ нь мөн л хуулийн цоорхой болон ашиглагдах боломжтой юм.

Ерөнхийдөө, өгүүлэгч миний үзэж байгаагаар хар тамхитай тэмцэх энэ тэмцлийн хүрээнд эрүүгийн хатуу ял шийтгэлийн бодлого баримтлах нь нэг талаар тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг хэлбэр бөгөөд нөгөө талаар эрүүгийн хариуцлагын зорилгыг хэрэгжүүлж буй явдал хэмээн үзэж, манай улсын хувьд хар тамхины гэмт хэрэгтэнд ял оногдуулахдаа ерөнхий байдлаар ялыг оноож, оноож буй ялын хэмжээ сул байгааг харгалзан үзэж, хамгийн чухал нь хар тамхины эсрэг бие даасан хуультай болох, дараагаар одоо мөрдөгдөж буй эрүүгийн хуульд заасан хар тамхитай холбоотой зохицуулалтыг сайжруулах, хар тамхины төрөл, нөлөөлөх байдал, хэмжээ зэргийг нарийвчлан тогтоон ялыг оновчтой, ялгавартай, оногдуулдаг байх шаардлагатай байгааг энд дурдлаа.

ЭХ СУРВАЛЖ

1. БНХАУ-ын Эрүүгийн хууль. 1979.

2. Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002.

3. Дээд шүүхийн тайлбар. 2008.

4. “Хар тамхины гэмт хэргийн мөн чанарыг судлах нь” (Хятад хэл дээрх нийтлэл). 2014.

5. Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх нийгэмлэгийн албан ёсны цахим хуудас.

<http://monantidrug.blogspot.com/>

6. Хууль зүйн мэдээллийн нэгдсэн системийн цахим хуудас.

<http://www.legalinfo.mn/>

Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, цагдаагийн ахмад Г.Оюунболд